ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Улаанбадрах сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: ДГА-2026/90/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: www.audit.mn

Дорноговь аймаг

2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий
Утас: 70522734 Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn

Аудитын менежер: У.Оюунтүлхүүр
Утас: 70523020 Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn

Ахлах аудитор: Э.Энхцэцэг
Цахим хаяг: enkhtsetsege@audit.gov.mn

Аудитор: Г.Мөнх-Оргил
Цахим хаяг: munkh-orgilg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.Аудитын санал дүгнэлт

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (976) 7052 2734
Цахим хуудас: dornogovi@audit.gov.mn

2026.02.25 № 1-6/88

танай_____________-ны №_______________-т

УЛААНБАДРАХ СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА А.МӨНХЦАЦРАЛ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Улаанбадрах сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант онд сумын иргэдийн Төлөөлөгчдийн 2025 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн 15 дугаар тогтоолоор 2025 оны төсвийг 51.1 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна. Нэмэгдүүлсэн төсвийг эдийн засгийн ангиллаар задалж үзвэл цалин хөлсний зардлыг 43.6 сая төгрөгөөр, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг 5.4 сая төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 1 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг 1.7 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 0.5 төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

442505055

Тайлант онд тус байгууллагын үйл ажиллагаанд онцлон дурдах асуудал илрээгүй болно.

**Бусад асуудлын хэсэг**

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Т.ГАН-ӨЛЗИЙ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **6,376,275.00** | **13,437,065.00** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 510,500.00 | 2,923,990.00 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 510,500.00 | 2,923,990.00 |
| **3121** | **Төгрөг** | 510,500.00 | 2,923,990.00 |
| 31215 | Нэмэлт санхүүжилтийн харилцах | 510,500.00 | 2,923,990.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 5,865,775.00 | 10,513,075.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 5,865,775.00 | 10,513,075.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 365,500.00 | 4,929,400.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 1,953,275.00 | 5,583,675.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 3,547,000.00 | - |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **15,595,630.56** | **11,573,940.49** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 15,595,630.56 | 11,573,940.49 |
| **392** | **Биет хөрөнгө** | 15,595,630.56 | 11,573,940.49 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 68,000,000.00 | 68,000,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (68,000,000.00) | (68,000,000.00) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 8,004,000.00 | 8,004,000.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (4,256,916.34) | (5,629,416.67) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 15,318,780.48 | 13,689,011.85 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (3,470,233.58) | (4,489,654.69) |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **21,971,905.56** | **25,011,005.49** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **31,800.00** | **13,662,413.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 31,800.00 | 13,662,413.00 |
| **413** | **Өглөг** | 31,800.00 | 13,662,413.00 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 31,800.00 | 1,397,713.00 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | - | 3,125,120.00 |
| **4136** | **Бусад өглөг** | - | 9,139,580.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | - | 7,247,680.00 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | - | 1,891,900.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **21,940,105.56** | **11,348,592.49** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 21,940,105.56 | 11,348,592.49 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 3,438,072.56 | 3,438,072.56 |
| 51101 | Өмч: - төрийн | 3,438,072.56 | 3,438,072.56 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 18,257,372.75 | 7,665,859.68 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 18,257,372.75 | 18,257,372.75 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | (10,591,513.07) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 244,660.25 | 244,660.25 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **21,971,905.56** | **25,011,005.49** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **199,484,351.01** | **225,514,299.33** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **199,484,351.01** | **225,514,299.33** |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 199,484,351.01 | 225,514,299.33 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 199,484,351.01 | 225,514,299.33 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **199,575,012.88** | **235,822,332.90** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **199,575,012.88** | **235,822,332.90** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 197,941,312.88 | 235,422,332.90 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 151,074,204.01 | 186,093,238.33 |
| 210101 | Үндсэн цалин | 58,725,069.85 | 62,197,226.64 |
| 210102 | Нэмэгдэл | 67,164,751.71 | 96,095,212.52 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 10,287,545.45 | 9,900,000.00 |
| 210104 | Урамшуулал | 14,896,837.00 | 17,900,799.17 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 17,199,660.00 | 23,603,200.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 11,041,800.00 | 16,050,300.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,468,200.00 | 1,888,200.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,174,500.00 | 944,100.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 427,460.00 | 944,100.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,087,700.00 | 3,776,500.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 9,112,402.00 | 12,102,860.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,494,400.00 | 2,011,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4,634,714.00 | 9,781,260.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 584,300.00 | 310,100.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 322,500.00 | - |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 2,076,488.00 | - |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 958,000.00 | 1,270,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 958,000.00 | 1,270,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 5,262,025.00 | 5,833,324.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 5,262,025.00 | 5,590,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | - | 115,830.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | - | 98,494.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | - | 29,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 14,335,021.87 | 6,519,710.57 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 7,824,100.00 | 2,631,500.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 377,500.00 | 150,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 6,133,421.87 | 3,738,210.57 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 1,633,700.00 | 400,000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 1,633,700.00 | 400,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,633,700.00 | 400,000.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(90,661.87)** | **(10,308,033.57)** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | - | 283,479.50 |
| 225010 | Үнэ төлбөргүй гарсан зардал-Үндсэн хөрөнгө | | 283,479.50 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | - | (283,479.50) |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(90,661.87)** | **(10,591,513.07)** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **199,484,351.01** | **228,327,789.33** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **-** | **2,813,490.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | - | 2,813,490.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | - | 2,813,490.00 |
| 1200047 | Шилжиж ирсэн хөрөнгө | | 2,813,490.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **199,484,351.01** | **225,514,299.33** |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 199,484,351.01 | 225,514,299.33 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 199,484,351.01 | 225,514,299.33 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **194,368,051.01** | **225,914,299.33** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **194,368,051.01** | **225,914,299.33** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **192,734,351.01** | **225,514,299.33** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 151,324,162.01 | 187,540,815.33 |
| 210101 | Үндсэн цалин | 59,383,879.85 | 65,010,716.64 |
| 210102 | Нэмэгдэл | 66,755,899.71 | 94,729,299.52 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 10,287,545.45 | 9,900,000.00 |
| 210104 | Урамшуулал | 14,896,837.00 | 17,900,799.17 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 17,128,000.00 | 23,603,200.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 11,103,900.00 | 16,050,300.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,468,200.00 | 1,888,200.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,174,500.00 | 944,100.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 293,700.00 | 944,100.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,087,700.00 | 3,776,500.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 5,620,464.00 | 3,624,960.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 905,900.00 | 1,647,400.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4,130,264.00 | 1,667,460.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 584,300.00 | 310,100.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 245,500.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 245,500.00 | - |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 958,000.00 | 1,270,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 958,000.00 | 1,270,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 12,958,725.00 | 8,721,324.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 12,958,725.00 | 8,478,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | - | 115,830.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | - | 98,494.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | - | 29,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 4,499,500.00 | 754,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 604,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,499,500.00 | 150,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **1,633,700.00** | **400,000.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 1,633,700.00 | 400,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,633,700.00 | 400,000.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **5,116,300.00** | **2,413,490.00** |

| | | | |
|---|---|---|---|
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **6,750,000.00** | **-** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **6,750,000.00** | **-** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 6,750,000.00 | - |
| 222001 | Тоног төхөөрөмж | 1,000,000.00 | - |
| 223001 | Бусад хөрөнгө | 5,750,000.00 | - |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(6,750,000.00)** | **-** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | (1,633,700.00) | 2,413,490.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | 510,500.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 510,500.00 | 2,923,990.00 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 3,438,072.56 | 244,660.25 | 18,257,372.75 | 21,940,105.56 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **3,438,072.56** | **244,660.25** | **18,257,372.75** | 21,940,105.56 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | - | - | - | - |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | - | - | - | - |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | | - |
| C08 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **3,438,072.56** | **244,660.25** | **18,257,372.75** | 21,940,105.56 |
| D01 | **2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **3,438,072.56** | **244,660.25** | **18,257,372.75** | 21,940,105.56 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **3,438,072.56** | **244,660.25** | **18,257,372.75** | 21,940,105.56 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | - | - | - |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | - | - | - | - |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - | - | - |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | (10,591,513.07) | (10,591,513.07) |
| D09 | **2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **3,438,072.56** | **244,660.25** | **7,665,859.68** | 11,348,592.49 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү |
|---|---|---|---|---|
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 241,390,600.00 | 225,514,299.33 | 15,876,300.67 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 241,390,600.00 | 225,514,299.33 | 15,876,300.67 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 240,790,600.00 | 225,514,299.33 | 15,276,300.67 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 187,565,800.00 | 187,540,815.33 | 24,984.67 |
| 210101 | Үндсэн цалин | 65,028,000.00 | 65,010,716.64 | 17,283.36 |
| 210102 | Нэмэгдэл | 94,729,100.00 | 94,729,299.52 | (199.52) |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 9,900,000.00 | 9,900,000.00 | - |
| 210104 | Урамшуулал | 17,908,700.00 | 17,900,799.17 | 7,900.83 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 23,603,400.00 | 23,603,200.00 | 200.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 16,050,200.00 | 16,050,300.00 | (100.00) |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,888,300.00 | 1,888,200.00 | 100.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 944,100.00 | 944,100.00 | - |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 944,100.00 | 944,100.00 | - |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,776,700.00 | 3,776,500.00 | 200.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 7,187,900.00 | 3,624,960.00 | 3,562,940.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,560,000.00 | 1,647,400.00 | 912,600.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4,027,900.00 | 1,667,460.00 | 2,360,440.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 600,000.00 | 310,100.00 | 289,900.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,834,000.00 | 1,270,000.00 | 564,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,834,000.00 | 1,270,000.00 | 564,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 17,949,500.00 | 8,721,324.00 | 9,228,176.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 17,700,000.00 | 8,478,000.00 | 9,222,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 116,000.00 | 115,830.00 | 170.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 98,500.00 | 98,494.00 | 6.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 35,000.00 | 29,000.00 | 6,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 2,650,000.00 | 754,000.00 | 1,896,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,500,000.00 | 604,000.00 | 1,896,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 150,000.00 | 150,000.00 | - |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 600,000.00 | - | 600,000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 600,000.00 | - | 600,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 600,000.00 | - | 600,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 241,390,600.00 | 225,514,299.33 | 15,876,300.67 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 241,390,600.00 | 225,514,299.33 | 15,876,300.67 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 241,390,600.00 | 225,514,299.33 | 15,876,300.67 |

## 5. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 2,813.5 мянган төгрөгийн 1 алдаа илэрснээс 2,813.5 мянган төгрөгийн 1 алдааг аудитын явцад бүрэн залруулсан.

### 5.1. Залруулсан алдаа

Аудитаар СТ-2А тайланд ахмадын сангийн орлогыг үр дүнгийн тайланд 2,813.5 мянган төгрөгийг зөрүүтэй тусган илэрхийлсэн.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| СҮДТ-д ахмадын сангийн орлого 2.8 сая төгрөгийг буруу тусган илэрхийлсэн байна. | 1 | 2,813.5 | | | 1 | 2,813.5 | 1 | 2,813.5 | - | - | - | - |
| **Дүн** | **1** | 2,813.5 | **-** | **-** | **1** | 2,813.5 | **1** | 2,813.5 | **-** | **-** | **-** | **-** |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | | | | | | | | | | |
| **Дүн** | - | - | - | - | - | - | - | - | | - |